



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/102

Булган сум

### Худалдан авалт хийх эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдээс захирамжийн хавсралтад заагдсан төсөл арга хэмжээнүүдийг батлагдсан төсөвт өртөгт багтаан холбогдох хууль, журмын дагуу худалдан авах эрхийг харьяалах байгууллагын дарга нарт олгосугай.


2. Тус худалдан авалтын санхүүжилтийг холбогдох хууль журам, гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт), Нягтлан бодогч (Б.Бумцэнд) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 29-ны өдрийн А/02 дугаар  
захирамжийн хавсралт



Д/д	Төсөл арга хэмжээний нэрс	Нийт төсөвт өртөг	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг	ХАА-нд мөрдөх журам	Эрх олгосон байгууллагын дарга
1	2	3	4	5	6
1	Аймгийн татварын хэлтсийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	15,000.0	15,000.0	ШХА	Татварын газар Д.Лхагвасүрэн
2	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн техник хэрэгсэл	8,000.0	8,000.0	ШХА	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс Б.Ариунболд
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэндийн үзлэгийн өрөөний тохижилт, тоног төхөөрөмж (Булган сум)	15,000.0	15,000.0	ШХА	Нийгмийн даатгалын газар Ц.Энх-Амгалан
4	Түр хамгаалах байрны тоног төхөөрөмж, тохижилт (Булган сум)	20,000.0	20,000.0	ШХА	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар Т.Баярбат
5	Иргэний танхимын сантехникийн засвар (Бугат сум)	20,000.0	20,000.0	ШХА	Засаг дарга Х.Ууганбаяр
6	Цөлжилт, элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор Рашаант суманд байгуулсан 2020, 2022 оны ойн зурвасанд механик хамгаалалт хийх (3га)	19,000.0	19,000.0	ШХА	Байгаль орчин, аялал жуулчлалын газар А.Гантөмөр
7	Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор эко жорлон барих (Зэд хантай бүтээлийн нуруу тусгай хамгаалалттай газрын захиргаа)	20,000.0	20,000.0	ШХА	Байгаль орчин, аялал жуулчлалын газар А.Гантөмөр
8	Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу хүрэн баавгайг аюулгүй болгох, амьд баригч, зөөвөрлөгч тор хийлгэх	5,300.0	5,300.0	ШХА	Байгаль орчин, аялал жуулчлалын газар А.Гантөмөр
9	Тарвага сэргээн нутагшуулах (Дашинчилэн сум)	18,000.0	18,000.0	ШХА	Байгаль орчин, аялал жуулчлалын газар А.Гантөмөр
10	Аймгийн аялал жуулчлалын танилцуулга, газрын зураг англи, монгол хэлээр хэвлүүлэх, санамж, брошурыг 5 төрлөөр хэвлүүлэх	20,000.0	20,000.0	ШХА	Байгаль орчин, аялал жуулчлалын газар А.Гантөмөр
<b>НИЙТ ДҮН</b>		<b>160,300.00</b>	<b>160,300.0</b>		